



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/572

Алтай хот

**Төсөл сонгон шалгаруулах хороо  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 78 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдээс ирсэн төслийг сонгон шалгаруулах хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга:	Г.Чинбат	-(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Д.Батбилэг	-(аймгийн Засаг даргын зөвлөх)
	Х.Баатарзориг	-(Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Ц.Эрдэнэбат	(Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Т.Сүхбаатар	-(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Б.Цэнд	-(аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын менежер) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга: Р.Цэнд-Аюуш - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Үйлвэрлэл эрхлэгчдээс ирүүлсэн төслийг журмын дагуу шалгаруулж, төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг хорооны дарга (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/01 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201001979